



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/201

Мандалговь

「Халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан」  
сэргийлэх вакцинжуулалтыг хурганд  
хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 -ын "а", Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малын гоц халдварт хонины Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулах хурганы тоог хавсралтаар баталсугай.

Хоёр. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг гүйцэтгэх ажлын хэсгийг сум, баг бүрд томилж, ажиллах хүч, техник хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Хургыг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулах ажлыг богино хугацаанд зохион байгуулан, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар /Б.Мөнхжаргал/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200635